

МОНГОЛ УЛС



БАРИЛГЫН ИНЖЕНЕР-ХАЙГУУЛЫН
"ГАНХОШУУ" ХХК

АРХИВ № 01 2016 008

ЗТ19-79/13



ДАРХАН-ЭРДЭНЭТ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС АМАРБАЯСГАЛАНТ
ХИЙД ХҮРТЭЛХ 33.4 КМ УРТТАЙ, ХАТУУ ХУЧИЛТТАЙ, АВТО
ЗАМЫН ТРАСС, ГҮҮР, ХООЛОЙ, ДАЛАНГИЙН МАТЕРИАЛЫН
ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ
АЖЛЫН ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот 2016 он



БАРИЛГЫН ИНЖЕНЕР-ХАЙГУУЛЫН
"ГАНХОШУУ" ХХК

АРХИВ № 01 2016-09-08

ЗТ19-79/13



Зохиогч: Л.Ганзориг



ДАРХАН-ЭРДЭНЭТ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС АМАРБАЯСГАЛАНТ
ХИЙД ХҮРТЭЛХ 33.4 КМ УРТТАЙ, ХАТУУ ХУЧИЛТТАЙ, АВТО
ЗАМЫН ТРАСС, ГҮҮР, ХООЛОЙ, ДАЛАНГИЙН МАТЕРИАЛЫН
ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ

АЖЛЫН ДҮГНЭЛТ



ЗАХИРАЛ

ИНЖЕНЕР

Л.Ганзориг

А.Назгүл

ГАРЧИГ

I. ОРШИЛ	3
II. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
II.1. БАЙРШИЛ	4
II.2. УУР АМЬСГАЛ	4
II.3. УУЛ ЗҮЙ	8
II.4. УС ЗҮЙ	8
II.5. ГЕОМОРФОЛОГИЙН ХЭВ ШИНЖ	8
II.6. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ	10
II.7. ГИДРОГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ	11
II.8. ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН ҮЗЭГДЭЛ, ҮЙЛ ЯВЦ	13
III. АВТО ЗАМЫН ЗУРВАС ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ БА ХӨРСНИЙ ФИЗИК-МЕХАНИК ШИНЖ ЧАНАР	14
IV. ДҮГНЭЛТ	19
V. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	25
VI. ЦООНОГИЙН КАТАЛОГИ	26
VII. ЦООНОГИЙН БИЧИГЛЭЛ	29
VIII. ЦООНОГИЙН ФОТО ХАВСРАЛТ	49

ХАВСРАЛТ

*БАЙРШЛЫН СХЕМ ЗУРАГ, ТАНИХ ТЭМДЭГ
ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН ЗҮСЭЛТҮҮД
ХӨРСНИЙ ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /СВР/
ХӨРСНИЙ УСНЫ ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ
ХӨРСНИЙ ФИЗИК ШИНЖ ЧАНАРЫН НЭГДСЭН ХҮСНЭГТ*



I. ОРШИЛ

Авто замын зураг төслийн "АР СИ ЭС СИ" ХХК болон "Ганхошуу" ХХК-ийн хооронд 2016 оны 3 дугаар сарын 28-ний өдөр байгуулсан гэрээнд үндэслэн. "Дархан-Эрдэнэт чиглэлийн авто замаас Амарбаясгалант хийд хүртлэх 33.4 км урттай, хатуу хучилттай, авто замын трасс, гүүр, хоолой, далангийн материалын инженер-геологийн судалгааны ажил"-ыг Барилгын Инженер Хайгуулын Үйлдвэрлэл, Эрдэм шинжилгээний "Ганхошуу" ХХК-д 2016 оны 4 дүгээр сарын 04-өөс 4 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл хээрийн өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэв.

Авто замын трассын инженер-геологийн хээрийн судалгааны ажлыг "Ганхошуу" ХХК-ийн инженер Л.Ганзоригийн удирдлагаар өрмийн мастер-жолооч Ё.Ганбаатар, инженер Ц.Сүхбаатар, өрмийн туслах Б.Нямсүрэн, Б.Батхишиг нарын бүрэлдэхүүнтэй бригад гүйцэтгэв.

Авто замын зурвас талбайд 15.0 м гүнтэй, 7 цооног, 4.0-6.0 м гүнтэй, 63 цооног өрөмдсөн. Судалгааны талбайд нийт 367.0 уртааш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, буурь хөрсний физик-механик шинж чанарыг тодорхойлох зорилгоор 30 ширхэг дээж авч лабораторийн шинжилгээг "Ганхошуу" ХХК-ийн инженер А.Назгүл, О.Нарангуа, Э.Энхжин нар хийж гүйцэтгэв. Авто замын итгэмжлэгдсэн "Лабо" ХХК-ийн лабораторид карьерийн материалд зориулж 4 дээжинд шинжилгээг хийлгэсэн болно. Хөрсний усны 2 дээжийн шинжилгээг Геоэкологийн хүрээлэнд тус тус хийлгэв. Хээрийн судалгааны явцад судалгааны талбай орчны геологи, геоморфологийн нөхцөл байдалд ажиглалт, судалгаа хийж бичиглэл үйлдэв. Захиалагчаас ирүүлсэн, дэвсгэр зураг болон дагуу зүсэлтийн зургаас цооногийн амсрын өндөржилтийг авч, цооногийн байршлын схем зурагт цооногуудыг байрлууллаа /Фото хавсралтыг үзнэ үү/. Хээрийн судалгааны материалууд болон лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэн авто зам зурвас, материалын хайгуулын инженер-геологийн судалгааны ажлын дүгнэлтийг ажлын зураг төсөл боловсруулах шатанд зориулан инженер Л.Ганзориг боловсруулав. Судалгааны ажилд холбогдох эх материалыг тайлангийн эх хувьд хавсарган "Ганхошуу" ХХК-ийн архивт хадгалав.

II. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

II.1. Байршил

Шинээр барихаар төлөвлөж буй 33.4 км авто замын трасс нь Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутагт байрлана. Авто замын трасс нь Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалант хийд чиглэлд 33.4 км үргэлжлэх ба тус зам нь хатуу хучилттай, авто зам барихаар төлөвлөсөн байна.

II.2. Уур амьсгал

Тухайн район нь цаг уурын хувьд Монгол орны цаг уурын ерөнхий нөхцөлийн адилаар эрс тэс уур амьсгалтай ерөнхий ангилалд хамаарагдах боловч орон нутгийн бичил цаг уурын өвөрмөц онцлогтой юм. Өвөлдөө хүйтэвтэр, зундаа сэрүүвтэр уур амьсгалтай юм. Судалгааны районы цаг, уурын үзүүлэлтүүдийг “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт” (БНБД 23-01-09)-ийн Сэлэнгэ аймаг. “Баруунбүрэн”, “Орхон” станцуудын үзүүлэлтийг хүснэгтээр өглөө.

Гаднах агаарын сар, жилийн дундаж температур, °C

Хүснэгт II-1

Станц	Сар												Жил
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Баруунбүрэн	-21.3	-16.8	-6.4	3.1	11.6	16.8	18.9	17.0	10.0	2.6	-9.3	-17.5	0.7
Орхон	-24.8	-19.6	-8.3	3.3	11.2	17.1	19.1	16.7	9.6	0.6	-11.3	-20.7	-0.6

Гадна агаарын үнэмлэхүй хамгийн их температур, °C

Хүснэгт II-2

Станц	Үнэмлэхүй хамгийн их	Он сар өдөр	VII сарын үнэмлэхүй ихийн дундаж
Орхон	43.4	1995.VII.5	29.8

Гадна агаарын үнэмлэхүй хамгийн бага температур, °C

Хүснэгт II-3

Станц	Үнэмлэхүй хамгийн бага	Он сар өдөр	I сарын үнэмлэхүй Бага дундаж
Орхон	-45.4	1979.XII.23	-37.4

Барилга, байгууламж, техник технологийн тооцооны температур, °С

Хүснэгт II-4

Станц	Гадна агаарын тооцооны температур, °С				Хамгийн халуун үеийн нэг хоногийн
	Хамгийн хүйтэн үеийн				
	1 хоног	3 хоног	5 хоног	Агаар сэлгэлтийн	
Баруунбүрэн	-32.8	31.7	-30.7	-22.0	27.4
Орхон	-37.8	-36.4	-35.3	-28.4	26.8

Галлагааны (халаалтын) хугацааны тооцооны үзүүлэлт

Хүснэгт II-5

Станц	Галлагааны (халаалтын) хугацаа				
	Эхлэх өдөр	Дуусах өдөр	Үргэлжлэх хоног	Халаалтын улирлын тооцооны дундаж температур, °С	Халаалтын улирлын эрчим, градус °С (-t)
Баруунбүрэн	23.IX	3.V	222	-8.6	-1900.8
Орхон	20.IX	3.V	225	-10.4	-2351.2

Гадна агаарын тооцооны параметр энтальпи

Хүснэгт II-6

Станц	Агаарын мм (гПа)	Жилийн үе	А параметр		Б параметр		В параметр	
			Температур, °С	Дулаан агууламж, (кДж/кг)	Температур, °С	Дулаан агууламж, (кДж/кг)	Температур, °С	Дулаан агууламж, (кДж/кг)
			Орхон	697(930)	Дулаан	23.5	48.9	30.6
Хүйтэн	-27.1	-26.2			-36.4	-35.5	-45.4	-45.1

Агаарын чийгшил, хур тунадасны хэмжээ

Хүснэгт II-7

Станц	Хур тунадас							
	Халуун сар	Хүйтэн сар	Жил	Дулаан үе	Хоногийн хамгийн их	Он	Сар	Өдөр
Орхон	52	76	301.6	283.5	79.0	1972	VI	13

Жил, сарын дундаж салхины хурд

Хүснэгт II-8

Станц	Сар, өвлийн улирал, жилийн дундаж хурд, м/с													
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Өвөл	Жил
Баруунбүрэн	1.8	1.8	2.4	3.0	2.5	2.1	1.8	2.0	2.1	2.0	1.7	1.5	1.7	2.1
Орхон	0.4	0.6	1.5	2.5	2.4	1.9	1.4	1.3	1.5	1.4	0.8	0.5	0.5	1.4



Аянгийн дуу цахилгааны муж

Хүснэгт II-9

Муж	Аянга дуу цахилгаантай			1 аянга минут	1 км ² талбайд ниргэх тоо
	Өдөр	Дундаж үргэлжлэх, цаг	Хамгийн удаан, цаг		
II	22-36/29/	43-50/46/	56-100	83-121/94/	5-6

Хурдас (нойтон цас, цан, мөстлөг) субилмацийн үзэгдлийн давтагдал, ачааллын муж

Хүснэгт II-10

Муж	Нойтон цастай		Цантай		Мөстлөгийн			
	өдрийн тоо	үргэлжлэх, цаг	өдрийн тоо	үргэлжлэх, цаг	өдрийн тоо	үргэлжлэх, цаг	Зузаан, /ачаалал/ мм	
							10 жилд	5 жилд
III	1-5	2-3	1-5	6-14	1-2	1-3	10	5

Салхины тооцооны хамгийн их хурд, м/с

Хүснэгт II-11

Муж	Газрын түвшнээс дээш өндөр, м			
	Газар /10/	100	200	500
1 жилд 1 удаа тохиолдох салхины хурд				
II	21-25/22/	31	34	38
5 жилд 1 удаа тохиолдох салхины хурд				
II	21-25 /23/	32	35	40
10 жилд 1 удаа тохиолдох салхины хурд				
II	21-25/23/	32	35	40
20 жилд 1 удаа тохиолдох салхины хурд				
II	26-30/28/	39	43	43

Монгол орны хөрсний улиралын хөлдөлт, гэсэлтийн уур амьсгалын муж

Хүснэгт II-12

Муж	Хөлдөлт			Гэсэлт			Тэг ⁰ С нэвчих гүн
	Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	
II	10-20.X /15.X/	1.V-10.VI /20.V/	195-200 /207/	1-20.IV /10.IV/	1.VI-1.VII /15.VI/	51-80 /65/	300-400 /350/

Монгол орны агаар мандлын (уур амьсгалын)
нөхцөлд металлын зэврэлт болох муж

Хүснэгт II-13

Муж	Металлын агаар мандлын зэврэлт болох уур амьсгалын комплекс үзүүлэлтийн нийлбэр үзүүлэлт
I	2000-2200

Монгол орны салхины шахац (ачаалал)-ын муж

Хүснэгт II-14

Салхины даралт $q_{\max} \text{ гН/м}^2$	Салхины даралт /шахац/-ын муж
	II
5 жилд 1 удаа	33
10 жилд 1 удаа	34
20 жилд 1 удаа	42

Судалгааны район Монгол орны газрын гадарга дээрх цасны ачааллын II мужид хамаарах ба цасан бүрхүүлийн нормчилсон ачаалал 50 /0.5/ кг/м² /гПа/ байна. Судалгааны талбайд тархсан хөрсний улирлын гэсэлтийн норматив гүнийг БНБД 23-01-09-ийн хүснэгт 23-аар өгвөл:

Баруунбүрэн станцаар:

- Шавар, шавранцар хөрсөнд 2.45 м
- Элсэнцэр, жижиг ширхэгтэй хөрсөнд 2.98 м
- Том ширхэгтэй элсэн хөрсөнд 3.15 м
- Том хэмжээст хөрсөнд 3.50 м

Орхон станцаар:

- Шавар, шавранцар хөрсөнд 2.61 м
- Элсэнцэр, жижиг ширхэгтэй хөрсөнд 3.17 м
- Том ширхэгтэй элсэн хөрсөнд 3.36 м
- Том хэмжээст хөрсөнд 3.73 м

Хадан хөрс илэрсэн тохиолдолд хадан хөрсний дээд хилээр тооцох

II.3. Уул зүй: Төлөвлөгдөж буй авто замын трасс нь эргэн тойрон нам, өндөртэй уулууд, ухаа толгодоор хүрээлэгдсэн байна. Тухайлбал трассын эхлэлийн урд талд Их Шилүүт уул, баруун хойт талд нь Бага Шилүүт уул (1224.8м), Цагаан хөтөл уул (1449.0м), Өлийн даваа (1245.3м), зүүн хойд талд нь Цагдуулын даваа (1340.5м), Банзрагч уул (1278.1м), Бүдүүн уул (1187.9м), Сүүлт уул (1170.4м), Шилүүст уул (1208.9м) зэрэг орчиндоо өндөртэй уултай. Нам өндөртэй уулууд болон ухаа, толгод, уул хоорондын болон ухаа толгодын хоорондын хөндий, голуудын хөндийнүүдийг гатлаж авто замын трасс үргэлжлэнэ.

II.4. Ус зүй: Судалгааны районд усан сүлжээ сайн хөгжсөн. Тухайлбал: Хонгорын нуруунаас эх авсан Еэвэнгийн гол, Ар мандлын нуруунаас эх авсан Хүжийн гол, Устай-Зүүний гол, Баянзүрх уулаас эх авсан Тэльдийн голууд болно. Эдгээр голуудад цутгаж байгаа олон жижиг горхи, булагууд дээрхи голуудад цутгаж, тэжээлд нь дэм үзүүлдэг байна. Дээрхи голуудын дундаж урсгалын хурд нь 0.4-1.0 л/сек орчим. Зун намрын хур бороотой үед тэжээл нь нэмэгдэж, урсгал нь ширүүсч, урсгалын хурд нь ихэсдэг байна. Өвөлдөө ёроолдоо хүртэл хөлддөг. Харин Еэвэн гол болон Устай-Зүүний гол нь хөндийгөөр байгаа булагууд өвөлдөө халиа, тошин үүсгэж, голуудын хөндийгөөр мөсөн бүрхүүл үүсгэдэг байна. Устай-Зүүний голын хөндийгөөр намгархаг гадаргуу үүссэн. Хар саарал өнгийн шавар хөрс 0.7-1.0 м-ийн зузаантайгаар тогтсон учраас өвлийн улиралд хөрсний овойлт үүсэж, газрын гадаргууд янз бүрийн хэлбэр, хэмжээтэй ан цавууд үүсдэг. Хүжийн голын орчинд дов сондуулгүй, хуурай гадаргуутай, физик-геологийн үзэгдэл үүсээгүй. Хөрсний усны түвшин нь 4.0 м-ээс илэрч, 3.8 м-т тогтсон. Нутгийн хүн, мал ундандаа дээрхи голуудын ус хэрэглэдэг бөгөөд одоогоор энэ орчинд гүний худаг байхгүй.

II.5. Геоморфологийн хэв шинж: Судалгааны район нь газар зүйн түгээмэл ангилалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн захын тойрогт хамаарагдана. Авто замын дагуух геоморфологийн хэв шинжийг газрын гадаргуугийн хэлбэр дүрс, ландшафтын нөхцөл зэргийг харьцуулан судалсны үндсэн дээр 3 хэв шинжид ангилан үзлээ. Үүнд:



- а) Уул толгодын хоорондын хөндийн хэв шинж
- б) Голуудын хөндийн хэв шинж
- в) Уул толгодын хэв шинж

Эдгээр 3 хэв шинжийг тус бүрд нь тодорхойлон авч үзье.

а. Уул толгодын хоорондын хөндийн хэв шинж:

Авто замын трассын эхлэлд байрлах Их шилүүт уул, Бага шилүүт уул (1224.8м), авто замын трассын зүүн талд байрлах 1241.1 м өндөртэй уул, мөн 1303.8 м өндөртэй уулуудын хоорондын хөндий, авто замын баруун талд байрлах 1309.3 м өндөртэй уул, зүүн талд байрлах Цагдуулын даваа уул (1340.5м), Банзрагч уул (1278.1м), мөн Агуйн ам уул, 1271.5 м өндөртэй уул, 1165.5м өндөртэй уул, 1098.0 м өндөртэй уул, Бүдүүн уул (1187.9м) өндөртэй уул болон замын зүүн талын төгсгөлийн хэсэгт байгаа нэргүй өндөрлөгтэй уул, толгодын хоорондын хөндий хамаарагдана. Уул толгодын хоорондын хөндийнүүд нь хойноосоо урагшаа аажим налуу тогтоцтой. Хийдийн орчим гүний ус 70.0-80.0 м-ийн гүнээс гарах магадлалтай.

б. Голуудын хөндийн хэв шинж:

Хангай нурууны салбар уулс болох Хонгорын нуруунаас эх авсан Еэвэн гол, Хүжийн гол, Ар мандалын нуруунаас эх авсан Устай-Зүүний голууд нийлж Еэвэн гол нэртэйгээр Орхон голд цутгах ба Еэвэн голд зүүн хойд талаас нь Тэльдийн гол, Еэвэн голд цутгана. Еэвэн гол, Хүжийн голын цутгал нийлж байгаа хэсэгт голын хөндий нийлээд өргөсөж, Бүдүүн уулаас доошлох тусам голын хөндий нарийсч байна. Еэвэн голын газрын гадаргуугийн өндөр нь Хийдийн доохно хэсэгт 1007.4 м, дунд хэсэгтээ 903.6 м, адгийн хэсэгтээ 748.5 м бөгөөд Еэвэн голын эх, адгийн өндрийн зөрүү нь 258.9 м болно. Голуудын хөндий нь зөөгдөл-хуримтлалын гадаргууд хамаарагдана. Голуудын хөндийн зарим хэсгээр дов сондуул бүхий намгархаг гадаргуу үүссэн. Өвлийн цагт халиа, тошин үүсдэг байна. Еэвэн гол, Хүжийн гол, Устай-Зүүний голууд дээр гүүр барихаар төлөвлөж трассын дагууд тус бүр дээр 15.0 м гүнтэй, нийт 7 цооногийг өрөмдөж хөрсний усны дээж авч лабораторид шинжлүүлсэн.



в. Уул толгодын хэв шинж:

Төлөвлөж буй авто замын дагууд байрлах 1296.0-1007.4 м өргөгдсөн нам өндөртэй уул, толгод, ухаа гүвээнүүд хамаарагдана. Эдгээр уул, толгод, ухаа гүвээ нь Өмнөд хэсгээрээ гүний гаралтай, боржингийн төрлийн чулуулгаас тогтсон бол дунд болон хойд хэсгээрээ тунамал гаралтай элсэн чулуу, занараас тогтсон байна. Дээрхи 2 төрлийн гарал үүсэлтэй чулуулаг нь гадаргуугийн физик өгөршилд хүчтэй орж ан цавлаг болсноос гадна зарим хэсэгтээ бул чулуу, хайр, хайрга болтлоо өгөршсөн байна. Дээрхи уул, толгодын чулуулгийг замын далан болон хучилтын материал болгон ашиглах боломжтой юм.

II.6. Геологийн тогтоц: Судалгааны районд геологи, гарал үүслийн 4 хурдас, чулуулгийг ангилан авч үзлээ. Үүнд:

а) Гуравдагч-дөрөвдөгч (Q_{III-IV})-ийн настай, аллюви-пролювийн гаралтай хурдас

Еэвэн гол, Хүжийн гол, Устай-Зүүний голуудын хөндийн дагууд үүсч хуримтлагдсан. Гуравдагч-дөрөвдөгч (Q_{III-IV})-ийн настай, аллюви-пролюви (ap)-ийн гаралтай хурдас дээрхи голуудын хөндийгөөр тархасан. Голлох хурдас нь элсэн болон элсэнцэр, шавранцар чигжээстэй сайр, сайрган хөрс болон янз бүрийн ширхэгтэй элсэн хөрс тархаснаас гадна элсэнцэр, шавранцар, шаврын мишил үеүд үндсэн цул үе дотор агуулагдана.

б) Уул, толгод хоорондын хөндий, бэл хормойн хурдас

Судалгааны районд нам өндөрлөгтэй уулс, ухаа, толгод өргөн тархасан бөгөөд тэдгээрийн хоорондын хөндий, ухаа, толгодын бэл хормойгоор Гуравдагч-дөрөвдөгч (Q_{III-IV})-ийн настай, делюви-пролюви (dp)-ийн гаралтай хурдас өргөн тархасан. Голлох хурдас нь элсэн болон элсэнцэр чигжээстэй хайр, хайрга, шавранцар чигжээстэй хайр, хайрга, бул чулуу агуулсан хайргархаг шавранцар, элсэнцэр, хайрга агуулсан элсэнцэр, шавранцар хөрс өргөн тархасан. Дээрхи хурдасны зузаан нь харилцан адилгүй, энэ нь газрын гадаргуугийн хэлбэр дүрс, хурдас хуримтлалын эрчим, орон зай, цаг хугацаанаас хамаарч байна. Дунджаар 5.0-10.0 м зарим хэсэгт 10.0-20.0 м хүртэл байна.

в) Палеозой (P_z)-н настай элсэн чулуу

Палеозойн эриний Карбон (С)-ны хэлтсийн настай тунамал гаралтай элсэн чулуу авто замын трассын хойд хэсгээр бэсрэг болон нам өндөртэй уул, толгодыг үүсгэж тогтсон. Голлон бор саарал, ногоовтор саарал, хөх саарал өнгө зонхилох бөгөөд жижиг ширхэгтэйгээс дунд зэргийн ширхэгтэй чулуулаг зонхилно. Элсэн чулуунаас тогтсон бэсрэг болон нам өндөртэй уулын чулуулаг нь өгөршлийн процессын үйл ажиллагаагаар нилээд өгөршиж, ан цавлаг болсноос гадна бутарч хайр, хайрга, бул чулуу болсон хэсгүүд ч байна. Энэ элсэн чулууг авто замын далан болон хучилтанд хэрэглэх боломжтой, нөөц ихтэй чулуулаг юм.

г) Дунд, дээд Палеозой (P_{z2-3})-н настай хурдас

Гүний гаралтай, хүчиллэг найрлагатай бор шаргал, бор саарал, улаавтар ягаан өнгийн дунд ширхэгтэй боржин чулуу авто замын трассын эхнээс дунд хэсэг хүртэл бэсрэг болон нам өндөртэй уул, толгодыг үүсгэж тогтсон байна. Боржин чулуунаас тогтсон чулуу нь он цагийн элэгдлээр ан цав үүсч бутарч хайр, бул чулуу болон үхэр чулууг үүсгэсэн байна. Гүний гаралтай боржин чулууг авто замын далан болон хучилтанд хэрэглэх бүрэн боломжтой, нөөц арвинтай, хатуулаг өндөртэй юм.

II.7. Гидрогеологийн нөхцөл

Шинээр барихаар төлөвлөж буй авто замын районд гидрогеологийн 3 уст давхарга тархасан байна. Үүнд:

а. Голуудын хөндийн аллювийн хурдасны аллюви-пролювийн гаралтай уст давхарга өргөн тархасан. Ус агуулагч голлох хурдас нь элсэн болон элсэнцэр чигжээстэй сайр, сайрга, төрөл бүрийн ширхэгтэй элсэн хөрс болно. Хөрсний ус голынхоо ойр хэсэгтээ 4.0-5.0 м-ээс илэрнэ. Голоосоо алслагдсан хэсгээсээ 8.0-12.0 м гүнээс илэрдэг болно. Судалгааны талбайд өрөмдсөн цооног № 61-ээс авсан хөрсний усны химийн шинжилгээгээр Гидрокарбонат ангийн, кальци-магнийн бүлгийн, II төрлийн найрлагатай, саармаг орчинтой, цэнгэг, зөөлөн ус болохын хамт бохирдолтын илрэл төдийл их биш хэмжээтэй илэрчээ. Тухайн уст цэгийн ус “Бетон болон барилгын зуурмагт хэрэглэх ус техникийн нөхцөл УСТ

3821-85” стандартын заалтыг хангаж байгаа болно. Цооног № 65-аас авсан хөрсний усны химийн найрлага нь Гидрокарбонат ангийн, кальци-магнийн бүлгийн, II төрлийн найрлагатай, саармаг орчинтой, хэт цэнгэг, зөөлөн ус болохын хамт бохирдолтын илрэл өчүүхэн хэмжээтэй байна. Тухайн уст цэгийн ус “Бетон болон барилгын зуурмагт хэрэглэх ус техникийн нөхцөл УСТ 3821-85” стандартын заалтыг хангаж байгаа болно. Усны ундрага нь 1.2-3.4 л/сек, шүүрэлтийн итгэлцүүр нь 60-180 м/хоног. Хөрсний ус болон гүний усны гол тэжээл нь зун, намрын улиралд орох хур, борооны ус бөгөөд гүнээс тэжээлийнхээ 20-25 хувийг авдаг байна. Бороо, хуртай үед гүний усны тэжээл нэмэгдэж, усны түвшин 1.0-1.5 м түр дээшлэнэ. Хөрсний ус нь бетон эдлэлд идэмхий чанар үзүүлэхгүй харин хар металл эдлэлд сулавтар зэврүүлэлт үзүүлнэ.

б. Делюви-пролювийн хурдасны уст давхарга: Уул, толгод, ухаа, гүвээний бэл хажуу, хоорондын хөндийгөөр делюви-пролювийн хурдасны уст давхарга ховор, алаг цоог байдлаар хуримтлагдсан байна. Ус агуулагч хурдас нь шавранцар, элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс түүнд агуулагдаж байгаа янз бүрийн ширхэгтэй элсний үеүд юм. Элсний үеүдийг дамжин хөрсний ус бүрэлдэн тогтдог байна. Делюви-пролювийн хурдасны ус нь ус өгөмж султай, ундрага багатай 0.1-0.5 л/сек-ээс үл хэтэрнэ. Ийм учраас төдийлөн ач холбогдол багатай. Зарим газартаа элсний үеүдийн байрлал, зузаан нимгэн болон элсний ширхэгийн хэмжээнээс хамаарч ус өгөмж сайтайгаар тохиолддог байна.

в. Чулуулгийн ан цавын ус: Судалгааны районд тархасан тунамал болон гүний гаралтай элсэн чулуу, боржингийн төрлийн чулуулагт ан цавын ус агуулагддаг байна. Ан цавын ус нь тухайн чулуулгийн эзлэх талбайн хэмжээгээр, бороо, хур орж байхад ан цаваар бороо, хурын ус дамжин, ан цавын усыг тэжээдэг улмаар ус өгөмжийг байнга арвижуулдаг байна. Ан цавын усны ундрага нь 1.2-3.6 л/сек-ийн хооронд хэлбэлздэг байна. Амарбаясгалант хийдийн орчинд ан цавын устай, дундажаар 70.0-80.0 м-ийн гүнээс гарах магадлалтай юм. Энэ нь хийдийн усан хангамжинд чухал ач холбогдол өгөх юм.

Хөрсний усны химийн найрлагын гол үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлээ.

№	Хөрсний усны дээж авсан байрлал	Дээж авсан цооног №	HCO_3^- -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр	Анион катионуудын нийлбэр	Дээж авсан гүн, м	Усны найрлагын томъёо /Курловын томъёо/
1	49°26.775', 105°04.876'	Ц-61	302.6 мг/дм ³	296.1 мг/дм ³	4.0	$M_{0.3} \frac{HCO_3^- 82.3 SO_4 13.6}{Ca^{2+} 56.6 Mg^{2+} 33.4}$
2	49°27.837', 105°05.188'	Ц-65	112.6 мг/дм ³	109.0 мг/дм ³	4.6	$M_{0.1} \frac{HCO_3^- 68.5 SO_4 28.6}{Ca^{2+} 41.1 Mg^{2+} 34.2 Na^+ 23.3}$

II.8. Инженер-геологийн үзэгдэл, үйл явц:

Авто замын трассын зарим хэсэг нь уулын хажуу, бэл хормойгоор үргэлжилж байгаа учраас бороо, хуртай үед газрын хэвгий дагаж, гадаргуугийн ус буух өндөр магадлалтай тул ус зайлуулах арга хэмжээг авах хэрэгтэй юм. Устай-Зүүний гол гатлаж байгаа хэсэгт шаварлаг хөрс 0.8-0.9 м-ийн зузаантай тархасан. Намгархаг гадаргуутай, дов сондуултай, газрын гадаргууд хүйтний хагарал янз бүрийн хэлбэр хэмжээтэй үүссэн байгаа нь шаварлаг хөрс хөлдөхдөө хүчтэй овойлт үүсгэхийг харуулж байна. Мөн Еэвэн голын хөндийн зарим хэсэгт шаварлаг хөрс зузаан тархасан, бага зэргийн дов сондуул үүссэн, намгархаг гадаргуутай байгааг анхаарах нь зүйтэй.

III. АВТО ЗАМЫН ЗУРВАС ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ БА ХӨРСНИЙ ФИЗИК - МЕХАНИК ШИНЖ ЧАНАР

Дархан-Эрдэнэтийн чиглэлийн авто замаас Амарбаясгалант хийд хүртэл 33.4 км урттай, хатуу хучилттай, авто замын трассын дагууд өрөмдсөн 68 цооногоос делюви-пролюви гаралтай, элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс, элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс, хайргархаг шавранцар хөрс болон Палеозойн настай, гүний гаралтай, боржин чулуу, Палеозойн настай, тунамал гаралтай, элсэн чулуу нь газрын гадаргуугийн хэлбэр дүрсээс хамаарч харилцан адилгүй зузаалагтайгаар авто замын далан болон өнгөн хөрсний доороос илэрсэн бөгөөд зарим хэсэгтээ хадан гарш нь ил гарсан байдалтайгаар тохиолдож байна. Иймд дээрхи хөрс, чулуулгийг нас гарал үүсэл, найрлага бүтцийг нь харгалзан үзэж инженер-геологийн 5 элемент (ИГЭ)-д ангилан авч үзлээ. Авто замын зурвас талбайд далан байдлаар, элсэнцэр, шавранцар хөрс бүхий асгамал хөрс 0.1-2.0 м зузаантайгаар хучиж тогтсон. Үүнд:

ИГЭ-1. Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс (*dp Q_{III-IV}*)

Бор саарал, бор шаргал, хар хүрэн өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, чийгтэй-усаар ханасан элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс. Бул чулуу 15-20% агуулсан. Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

• Хайр, хайрга	71.0
• Элс	22.8
• Тоос	4.0
• Шавар	2.2 тус тус агуулагдана.

Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

• Байгалийн чийг, хувь	0.122
• Хувийн жин, г/см ³	2.68
• Эзэлхүүн жин, г/см ³	2.19
• Цогцсын эзэлхүүн жин, г/см ³	2.02

- Сүвшил, % 24.72
- Сүвшлийн итгэлцүүр 0.328
- Чийглэгийн зэрэг 1.0

Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 2.02.01-94-ийн 1 дүгээр хүснэгтээр өглөө.

Норматив утга:

- Зууралдлын хүч $C^H = 2 \text{ кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^H = 40^\circ$
- Хэв гажилтын модуль $E = 45 \text{ МПа}$

Тооцооны утга:

- Зууралдлын хүч $C^I = 1.33 \text{ кПа}$ $C^{II} = 2 \text{ кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^I = 36^\circ$ $\varphi^{II} = 40^\circ$
- Тооцооны эсэргүүцэл $R_0 = 600 \text{ кПа}$

Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл: 650-730 Ом.м байна. Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс овойлтгүй хөрсөнд нормчилогдоно. Элсэн чигжээстэй хайр, хайрга, сайр, сайрган хөрсний байгалийн нурлын өнцөг: Хуурай нөхцөлд $41^\circ 32' 11''$, устай нөхцөлд $38^\circ 24' 36''$ байна. Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад- IV.

ИГЭ - 2. Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс ($dp Q_{III-IV}$)

Бор хүрэн, хар хүрэн, улбар шаргал, цайвар шаргал, бор шаргал, бор ногоон, хар саарал өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, хагас хатуу-урсамтгай консистенцтэй, элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс. Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл /%/:

- Хайр, хайрга 57.8
- Элс 25.5
- Тоос 9.4
- Шавар 7.3 тус тус агуулна.

Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл:

• Байгалийн чийг, хувь	0.168
• Урсалтын хязгаар дахь чийг, хувь	0.170
• Имрэгдлийн хязгаар дахь чийг, хувь	0.118
• Уян налархайн тоо, хувь	0.052
• Хувийн жин, г/см ³	2.70
• Эзэлхүүн жин, г/см ³	2.19
• Цогцсын эзэлхүүн жин, г/см ³	1.92
• Сүвшил, %	28.74
• Сүвшлийн итгэлцүүр	0.406
• Чийглэгийн зэрэг	1.15
• Консистенц	0.96

Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив утгыг БНБД 2.02.01-94-ийн 4, 5 * дугаар хавсралтаар өглөө:

Норматив утга:

• Зууралдлын хүч	$C^H = 6 \text{ кПа}$
• Дотоод үрэлтийн өнцөг	$\phi^H = 44^\circ$
• Хэв гажилтын модуль	$E = 44 \text{ МПа}$

Тооцооны утга:

• Зууралдлын хүч	$C^I = 4 \text{ кПа}$	$C^{II} = 6 \text{ кПа}$
• Дотоод үрэлтийн өнцөг	$\phi^I = 38^\circ$	$\phi^{II} = 44^\circ$
• Тооцооны эсэргүүцэл	$R_0 = 300 \text{ кПа}$	

Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл 280-350 Ом.м байна. Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад IV байна. Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс нь сулавтар хүчтэй овойлттой хөрсөнд нормчилогдоно.

ИГЭ-3. Хайргархаг шавранцар хөрс ($dp Q_{III-IV}$)

Улаан хүрэн, улаан, бор шаргал, бор саарал, хар хүрэн,цайвар саарал өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, хагас хатуу-урсамтгай консистенцтэй, хайргархаг шавранцар хөрс. Хайргархаг шавранцар хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):



- Хайр, хайрга 36.5
- Элс 37.9
- Тоос 14.5
- Шавар 11.1 тус тус агуулна.

Хайргархаг шавранцар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

- Байгалийн чийг, хувь 0.199
- Урсалтын хязгаар дахь чийг 0.283
- Имрэгдлийн хязгаар дахь чийг 0.168
- Уян налархайн тоо 0.116
- Хувийн жин, г/см³ 2.70
- Эзэлхүүн жин, г/см³ 2.17
- Цогцсын эзэлхүүн жин, г/см³ 1.81
- Сүвшил, % 32.94
- Сүвшлийн итгэлцүүр 0.492
- Чийглэгийн зэрэг 1.09
- Консистенц 0.27

Хайргархаг шавранцар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 2.02.01-94-ийн 2, 3 дугаар хүснэгтээр өглөө.

Норматив утга:

- Зууралдлын хүч $C^H = 45 \text{ кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^H = 21^\circ$
- Хэв гажилтын модуль $E = 31 \text{ МПа}$

Тооцооны утга:

- Зууралдлын хүч $C^I = 30 \text{ кПа}$ $C^{II} = 45 \text{ кПа}$
- Дотоод үрэлтийн өнцөг $\varphi^I = 18^\circ$ $\varphi^{II} = 21^\circ$
- Тооцооны эсэргүүцэл $R_0 = 250 \text{ кПа}$

Хайргархаг шавранцар хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл 32-40 Ом.м байна. Хайргархаг шавранцар хөрс хүчтэй овойлттой хөрсөнд нормчилогдоно. Хайргархаг шавранцар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад- II.



ИГЭ-4. Элсэн чулуу

Бор ногоон, цайвар саарал, цайвар ногоон өнгөтэй, Палеозойн настай, тунамал гаралтай, элсэн чулуу түүний хүчтэй өгөршил.

Эзлэхүүн жин, г/см³:

- өгөршөөгүй 2.67

- өгөршсөн 2.37

Өгөршлийн зэрэг 0.88

Хатуулаг:

- өгөршөөгүй VII (Өрөмдлөг, тэсэлгээний аргаар малтана)

- өгөршсөн VI (Хийн цохилтод төхөөрөмжөөр сулруулж малтана)

Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, кгс/см²

$$R_0 = 5.0 \text{ кгс/см}^2$$

ИГЭ-5. Боржин чулуу

Бор шаргал, улаандуу, цайвар ногоон, бор ногоон өнгөтэй, Палеозойн настай, гүний гаралтай, боржин чулуу, түүний хүчтэй өгөршил.

Эзлэхүүн жин, г/см³:

- өгөршөөгүй 2.74

- өгөршсөн 2.54

Өгөршлийн зэрэг 0.92

Хатуулаг:

- өгөршөөгүй VII (Өрөмдлөг, тэсэлгээний аргаар малтана)

- өгөршсөн VI (Хийн цохилтод төхөөрөмжөөр сулруулж малтана)

Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, кгс/см²

$$R_0 = 5.0 \text{ кгс/см}^2$$



IV. ДУГНЭЛТ

1. Авто замын зурвас талбай нь Геоморфологийн хувьд: Судалгааны район нь газар зүйн түгээмэл ангилалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн захын тойрогт хамаарагдана. Авто замын дагуух геоморфологийн хэв шинжийг газрын гадаргуугийн хэлбэр дүрс, ландшафтын нөхцөл зэргийг харьцуулан судалсны үндсэн дээр 3 хэв шинжид ангилагдана. Геологийн тогтоцын хувьд: Судалгааны районд геологи, гарал үүслийн 4 хурдас, чулуулгийг ангилан авч үзлээ. Үүнд:

а) Гуравдагч-дөрөвдөгч (Q_{III-IV})-ийн настай, аллюви-пролювийн гаралтай хурдас

Еэвэн гол, Хүжийн гол, Устай-Зүүний голуудын хөндийн дагууд үүсч хуримтлагдсан. Гуравдагч-дөрөвдөгч (Q_{III-IV})-ийн настай, аллюви-пролюви (ap)-ийн гаралтай хурдас дээрхи голуудын хөндийгөөр тархасан. Голлох хурдас нь элсэн болон элсэнцэр, шавранцар чигжээстэй сайр, сайрган хөрс болон янз бүрийн ширхэгтэй элсэн хөрс тархаснаас гадна элсэнцэр, шавранцар, шаврын мишил үеүд үндсэн цул үе дотор агуулагдана.

б) Уул, толгод хоорондын хөндий, бэл хормойн хурдас

Судалгааны районд нам өндөрлөгтэй уулс, ухаа, толгод өргөн тархасан бөгөөд тэдгээрийн хоорондын хөндий, ухаа, толгодын бэл хормойгоор Гуравдагч-дөрөвдөгч (Q_{III-IV})-ийн настай, делюви-пролюви (dp)-ийн гаралтай хурдас өргөн тархасан. Голлох хурдас нь элсэн болон элсэнцэр чигжээстэй хайр, хайрга, шавранцар чигжээстэй хайр, хайрга, бул чулуу агуулсан хайргархаг шавранцар, элсэнцэр, хайрга агуулсан элсэнцэр, шавранцар хөрс өргөн тархасан. Дээрхи хурдасны зузаан нь харилцан адилгүй, энэ нь газрын гадаргуугийн хэлбэр дүрс, хурдас хуримтлалын эрчим, орон зай, цаг хугацаанаас хамаарч байна. Дунджаар 5.0-10.0 м зарим хэсэгт 10.0-20.0 м хүртэл байна.

в) Палеозой (P_z)-н настай элсэн чулуу

Палеозойн эриний Карбон (C)-ны хэлтсийн настай тунамал гаралтай элсэн чулуу авто замын трассын хойд хэсгээр бэсрэг болон нам өндөртэй уул, толгодыг үүсгэж тогтсон. Голлон бор саарал, ногоовтор саарал, хөх саарал



өнгө зонхилох бөгөөд жижиг ширхэгтэйгээс дунд зэргийн ширхэгтэй чулуулаг зонхилно. Элсэн чулуунаас тогтсон бэсрэг болон нам өндөртэй уулын чулуулаг нь өгөршлийн процессын үйл ажиллагаагаар нилээд өгөршиж, ан цавлаг болсноос гадна бутарч хайр, хайрга, бул чулуу болсон хэсгүүд ч байна. Энэ элсэн чулууг авто замын далан болон хучилтанд хэрэглэх боломжтой, нөөц ихтэй чулуулаг юм.

г) Дунд, дээд Палеозой (P_{2-3})-н настай хурдас

Гүний гаралтай, хүчиллэг найрлагатай бор шаргал, бор саарал, улаавтар ягаан өнгийн дунд ширхэгтэй боржин чулуу авто замын трассын эхнээс дунд хэсэг хүртэл бэсрэг болон нам өндөртэй уул, толгодыг үүсгэж тогтсон байна. Боржин чулуунаас тогтсон чулуу нь он цагийн элэгдлээр ан цав үүсч бутарч хайр, бул чулуу болон үхэр чулууг үүсгэсэн байна. Гүний гаралтай боржин чулууг авто замын далан болон хучилтанд хэрэглэх бүрэн боломжтой, нөөц арвинтай, хатуулаг өндөртэй юм.

Гидрогеологийн хувьд: Шинээр барихаар төлөвлөж буй авто замын районд гидрогеологийн 3 уст давхарга тархсан байна. Үүнд:

а. Голуудын хөндийн аллювийн хурдасны аллюви-пролювийн гаралтай уст давхарга өргөн тархсан. Ус агуулагч голлох хурдас нь элсэн болон элсэнцэр чигжээстэй сайр, сайрга, төрөл бүрийн ширхэгтэй элсэн хөрс болно. Хөрсний ус голынхоо ойр хэсэгтээ 4.0-5.0 м-ээс илэрнэ. Голоосоо алслагдсан хэсгээсээ 8.0-12.0 м гүнээс илэрдэг болно. Судалгааны талбайд өрөмдсөн цооног № 61-ээс авсан хөрсний усны химийн шинжилгээгээр Гидрокарбонат ангийн, кальци-магнийн бүлгийн, II төрлийн найрлагатай, саармаг орчинтой, цэнгэг, зөөлөн ус болохын хамт бохирдолтын илрэл төдийл их биш хэмжээтэй илэрчээ. Тухайн уст цэгийн ус “Бетон болон барилгын зуурмагт хэрэглэх ус техникийн нөхцөл УСТ 3821-85” стандартын заалтыг хангаж байгаа болно. Цооног № 65-аас авсан хөрсний усны химийн найрлага нь Гидрокарбонат ангийн, кальци-магнийн бүлгийн, II төрлийн найрлагатай, саармаг орчинтой, хэт цэнгэг, зөөлөн ус болохын хамт бохирдолтын илрэл өчүүхэн хэмжээтэй байна. Тухайн уст цэгийн ус “Бетон болон барилгын зуурмагт хэрэглэх ус техникийн нөхцөл УСТ 3821-85” стандартын заалтыг хангаж байгаа болно. Усны ундрага нь 1.2-3.4 л/сек,



шүүрэлтийн итгэлцүүр нь 60-180 м/хоног. Хөрсний ус болон гүний усны гол тэжээл нь зун, намрын улиралд орох хур борооны ус бөгөөд гүнээс тэжээлийнхээ 20-25 хувийг авдаг байна. Бороо, хуртай үед гүний усны тэжээл нэмэгдэж, усны түвшин 1.0-1.5 м түр дээшлэнэ. Хөрсний ус нь бетон эдлэлд идэмхий чанар үзүүлэхгүй харин хар металл эдлэлд сулавтар зэврүүлэлт үзүүлнэ.

б. Делюви-пролювийн хурдасны уст давхарга: Уул, толгод, ухаа, гүвээний бэл хажуу, хоорондын хөндийгөөр делюви-пролювийн хурдасны уст давхарга ховор, алаг цоог байдлаар хуримтлагдсан байна. Ус агуулагч хурдас нь шавранцар, элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс түүнд агуулагдаж байгаа янз бүрийн ширхэгтэй элсний үеүд юм. Элсний үеүдийг дамжин хөрсний ус бүрэлдэн тогтдог байна. Делюви-пролювийн хурдасны ус нь ус өгөмж султай, ундрага багатай 0.1-0.5 л/сек-ээс үл хэтэрнэ. Ийм учраас төдийлөн ач холбогдол багатай. Зарим газартаа элсний үеүдийн байрлал, зузаан нимгэн болон элсний ширхэгийн хэмжээнээс хамаарч ус өгөмж сайтайгаар тохиолддог байна.

в. Чулуулгийн ан цавын ус: Судалгааны районд тархсан тунамал болон гүний гаралтай элсэн чулуу, боржингийн төрлийн чулуулагт ан цавын ус агуулагддаг байна. Ан цавын ус нь тухайн чулуулгийн эзлэх талбайн хэмжээгээр, бороо, хур орж байхад ан цаваар бороо, хурын ус дамжин, ан цавын усыг тэжээдэг улмаар ус өгөмжийг байнга арвижуулдаг байна. Ан цавын усны ундрага нь 1.2-3.6 л/сек-ийн хооронд хэлбэлздэг байна. Амарбаясгалант хийдийн орчинд ан цавын устай, дундажаар 70.0-80.0 м-ийн гүнээс гарах магадлалтай юм. Энэ нь хийдийн усан хангамжинд чухал ач холбогдол өгөх юм.

Хөрсний усны химийн найрлагын гол үзүүлэлтийг хүснэгтээр үзүүллээ.
Хүснэгт IV-1

№	Хөрсний усны дээж авсан байрлал	Дээж авсан цооног №	HCO_3^- -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр	Анион катионуудын нийлбэр	Дээж авсан гүн, м	Усны найрлагын томъёо /Курловын томъёо/
1	49°26.775', 105°04.876'	Ц-61	302.6 мг/дм ³	296.1 мг/дм ³	4.0	$M_{0.3} \frac{HCO_3^- 82.3 SO_4 13.6}{Ca^{2+} 56.6 Mg^{2+} 33.4}$



2	49°27.837', 105°05.188'	Ц-65	112.6 мг/дм ³	109.0 мг/дм ³	4.6	$M_{0.1} \frac{HCO_3^- 68.5 SO_4 28.6}{Ca^{2+} 41.1 Mg^{2+} 34.2 Na^+ 23.3}$
---	-------------------------	------	--------------------------	--------------------------	-----	--

Авто замын зурвас талбай нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй талбайд ангилагдана.

2. Авто замын зурвас талбайд тархсан хөрсний газар шорооны ажлын зэрэг болон овойлтын хүчийг IV-2 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт IV-2

ИГЭ	Хөрсний төрөл	Газар шорооны ажлын зэрэг	Овойлтын хүч
1	Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс	IV	-
2	Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс	IV	Сулавтар хүчтэй
3	Хайргархаг шавранцар хөрс	II	Хүчтэй
4	Элсэн чулуу	VI/VII	-
5	Боржин	VI/VII	-

3. Авто замын зурвас талбайд тархсан буурь хөрсний механик шинж чанарын норматив үзүүлэлтийг IV-3 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт IV-3

Хөрсний төрөл	Эзлэхүүн жин	Дотоод үрэлтийн өнцөг		Зууралдлын хүч		Хэв гажилтын Модуль
	$\gamma_{эз}$	ϕ^I	ϕ^{II}	C^I	C^{II}	E^H
	г/см ³	градус		кПа		МПа
Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс	2.19	36	40	1.3	2	45
Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс	2.19	38	44	4	6	44
Хайргархаг шавранцар хөрс	2.17	18	21	30	45	31

Элсэн чулуу:

Эзлэхүүн жин, г/см³:

- өгөршөөгүй 2.67

- өгөршсөн 2.37

Өгөршлийн зэрэг 0.88

Хатуулаг:

- өгөршөөгүй VII (Өрөмдлөг, тэсэлгээний аргаар малтана)

- өгөршсөн VI (Хийн цохилтод төхөөрөмжөөр сулруулж малтана)

Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, кгс/см²

$$R_0 = 5.0 \text{ кгс/см}^2$$

Боржин чулуу:

Эзлэхүүн жин, г/см³:

- өгөршөөгүй 2.74

- өгөршсөн 2.54

Өгөршлийн зэрэг 0.92

Хатуулаг:

- өгөршөөгүй VII (Өрөмдлөг, тэсэлгээний аргаар малтана)

- өгөршсөн VI (Хийн цохилтод төхөөрөмжөөр сулруулж малтана)

Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, кгс/см²

$$R_0 = 5.0 \text{ кгс/см}^2$$

4. Авто замын зурвас талбайд тархсан хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн, м:

Баруунбүрэн станцаар:

- Шавар, шавранцар хөрсөнд 2.45 м

- Элсэнцэр, жижиг ширхэгтэй хөрсөнд 2.98 м

- Том ширхэгтэй элсэн хөрсөнд 3.15 м

- Том хэмжээст хөрсөнд 3.50 м

Орхон станцаар:

- Шавар, шавранцар хөрсөнд 2.61 м

- Элсэнцэр, жижиг ширхэгтэй хөрсөнд 3.17 м

- Том ширхэгтэй элсэн хөрсөнд 3.36 м

- Том хэмжээст хөрсөнд 3.73 м

Хадан хөрс илэрсэн тохиолдолд хадан хөрсний дээд хилээр тооцох

5. Авто замын зурвас талбайд тархсан хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл /Ом.м/:

- Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс	- 650-730
- Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс	- 280-350
- Хайргархаг шавранцар хөрс	- 32-40
- Элсэн чулуу	- 180-280
- Боржин	- 270-400

6. Судалгааны районд газар хөдлөлтийн 7_2 баллын бүсэд хамаарна.

Зөвлөмж:

Авто замын трассын зарим хэсэг нь уулын хажуу, бэл хормойгоор үргэлжилж байгаа учраас бороо, хуртай үед газрын хэвгий дагаж, гадаргуугийн ус буух өндөр магадлалтай тул ус зайлуулах арга хэмжээг авах хэрэгтэй юм. Устай-Зүүний гол гатлаж байгаа хэсэгт шаварлаг хөрс 0.8-0.9 м-ийн зузаантай тархсан. Намгархаг гадаргуутай, дов сондуултай, газрын гадаргууд хүйтний хагарал янз бүрийн хэлбэр хэмжээтэй үүссэн байгаа нь шаварлаг хөрс хөлдөхдөө хүчтэй овойлт үүсгэхийг харуулж байна. Мөн Еэвэн голын хөндийн зарим хэсэгт шаварлаг хөрс зузаантай тархсан, бага зэргийн дов сондуул үүссэн, намгархаг гадаргуутай байгааг анхаарах нь зүйтэй.

Товч дүгнэлт бичсэн инженер:



Л.Ганзориг

А.Назгул

О.Нарангуа



V. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Барилгын инженер-геологийн ажил. БНБД 11-03-01. УБ., 2002 он.
2. Пособие по проектированию оснований зданий и сооружений /к СНиП 2.02.01-83/. М., 1986.
3. СНиП IV-5-82 Сборник-1. Земляные работы 1982 г.
4. Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНБД 23-01.01
5. Газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм.
БНБД 22-01-01*/2006
6. Суурин боловсруулалтын ажилд хэрэглэх заавар, гарын авлага,
аргачлалын эмхтгэл. УБ., 1985 он.
7. Хөрсний лабораторийн шинжилгээ хийх УСТ-ууд
8. Монгол орны физик газар-зүй. Ш.Цэгмид., УБ.1969 он

VI. ЦОНОГИЙН КАТАЛОГИ

а. Дархан-Эрдэнэтийн замаас Амарбаясгалант хийд хүртлэх
33.4 км урттай, хатуу хучилттай авто замын трассын дагууд
өрөмдсөн цооногийн каталоги

Д/д	Цооногийн дугаар, ПК-ийн дугаар	Малгал-тын гүн, м	Солбилцол		Үнэмлэ-хүй өндөр, м	Хөрсний усны түвшин, м		Өрөмдсөн он, сар, өдөр
			х	у		Илэрсэн гүн, м	Тогтсон гүн, м	
0	1	2	3	4	5	6	7	8
1	Ц-1 ПК-0+40	4.0	49° 12.818'	104° 59.121'	930.091	-	-	2016.04.04
2	Ц-2 ПК-0+500	4.0	49° 59.090'	104° 59.090'	936.002	-	-	2016.04.04
3	Ц-3 ПК-1+000	4.0	49° 13.332'	104° 59.047'	943.732	-	-	2016.04.04
4	Ц-4 ПК-1+700	4.0	49° 13.701'	104° 59.037'	961.199	-	-	2016.04.04
5	Ц-5 (Хо-3) ПК-2+180	4.0	49° 13.954'	104° 58.926'	981.117	-	-	2016.04.04
6	Ц-6 (Хо-4) ПК-2+760	4.0	49° 14.260'	104° 58.824'	996.432	-	-	2016.04.04
7	Ц-7 (Хо-5) ПК-2+940	4.0	49° 14.353'	104° 58.781'	1000.172	-	-	2016.04.04
8	Ц-8 (Хо-6) ПК-3+540	4.0	49° 14.675'	104° 58.695'	1007.561	-	-	2016.04.04
9	Ц-9 (Хо-7) ПК-4+60	4.0	49° 14.934'	104° 58.557'	1015.422	-	-	2016.04.04
10	Ц-10 (Хо-8) ПК-4+420	4.0	49° 15.130'	104° 58.501'	1020.318	-	-	2016.04.04
11	Ц-11 (Хо-9) ПК-5+40	4.0	49° 15.458'	104° 58.392'	1030.036	-	-	2016.04.05
12	Ц-12 (Хо-10) ПК-5+480	4.0	49° 15.681'	104° 58.311'	1032.868	-	-	2016.04.05
13	Ц-13 (Хо-11) ПК-5+960	4.0	49° 15.942'	104° 58.227'	1039.517	-	-	2016.04.05
14	Ц-14 ПК-6+500	4.0	49° 16.210'	104° 58.072'	1044.570	-	-	2016.04.05
15	Ц-15 (Хо-12) ПК-7+000	4.0	49° 16.464'	104° 57.919'	1050.602	-	-	2016.04.05
16	Ц-16 (Хо-13) ПК-7+440	4.0	49° 16.680'	104° 57.778'	1066.254	-	-	2016.04.05
17	Ц-17 (Хо-14) ПК-7+620	4.0	49° 16.772'	104° 57.717'	1073.911	-	-	2016.04.05
18	Ц-18 ПК-8+180	4.0	49° 17.078'	104° 57.670'	1096.537	-	-	2016.04.05
19	Ц-19 (Хо-15) ПК-8+400	4.0	49° 17.163'	104° 57.798'	1104.487	-	-	2016.04.05
20	Ц-20 (Хо-16) ПК-8+560	4.0	49° 17.207'	104° 57.901'	1107.898	-	-	2016.04.05
21	Ц-21 (Хо-17) ПК-8+860	6.0	49° 17.314'	104° 58.206'	1107.450	6.0	5.5	2016.04.06
22	Ц-22 ПК-9+780	4.0	49° 17.593'	104° 58.644'	1175.202	-	-	2016.04.06
23	Ц-23 (Хо-19) ПК-10+80	6.0	49° 17.672'	104° 58.867'	1151.327	-	-	2016.04.06
24	Ц-24 (Хо-20) ПК-10+380	4.0	49° 17.758'	104° 59.076'	1139.544	-	-	2016.04.06
25	Ц-25 (Хо-21) ПК-10+530	6.0	49° 17.797'	104° 59.187'	1126.228	-	-	2016.04.06
26	Ц-26 (Хо-22)	4.0	49° 17.942'	104° 59.487'	1113.566	-	-	2016.04.06



	ПК-10+980							
27	Ц-27 (Хо-23) ПК-12+160	4.0	49° 18.480'	104° 00.024'	1078.487	-	-	2016.04.06
28	Ц-28 (Хо-24) ПК-12+860	4.0	49° 18.787'	105° 00.363'	1065.632	-	-	2016.04.06
29	Ц-29 (Хо-25) ПК-13+40	4.0	49° 18.880'	105° 00.401'	1057.798	-	-	2016.04.06
30	Ц-30 ПК-13+580	4.0	49° 19.069'	105° 00.753'	1044.985	-	-	2016.04.06
31	Ц-31 (Хо-26) ПК-14+300	4.0	49° 19.404'	105° 01.069'	1025.626	-	-	2016.04.07
32	Ц-32 (Хо-27) ПК-14+480	4.0	49° 19.504'	105° 01.139'	1022.898	-	-	2016.04.07
33	Ц-33 ПК-14+980	4.0	49° 19.768'	105° 01.121'	1034.249	-	-	2016.04.07
34	Ц-34 (Хо-28) ПК-15+440	4.0	49° 19.884'	105° 01.469'	1019.377	-	-	2016.04.07
35	Ц-35 (Хо-29) ПК-16+20	4.0	49° 20.131'	105° 01.765'	1004.303	-	-	2016.04.07
36	Ц-36 (Хо-30) ПК-16+720	4.0	49° 20.314'	105° 02.293'	988.015	-	-	2016.04.07
37	Ц-37 ПК-17+260	4.0	49° 20.601'	105° 02.355'	981.255	-	-	2016.04.07
38	Ц-38 (Хо-31) ПК-17+760	4.0	49° 20.879'	105° 02.357'	989.755	-	-	2016.04.07
39	Ц-39 ПК-18+440	4.0	49° 21.245'	105° 02.398'	1024.487	-	-	2016.04.07
40	Ц-40 (Хо-32) ПК-18+760	4.0	49° 21.383'	105° 02.561'	1042.806	-	-	2016.04.07
41	Ц-41 (Хо-33) ПК-19+300	4.0	49° 21.613'	105° 02.822'	1021.496	-	-	2016.04.08
42	Ц-42 (Хо-34) ПК-19+660	4.0	49° 21.735'	105° 02.050'	1010.854	-	-	2016.04.08
43	Ц-43 (Хо-35) ПК-20+280	4.0	49° 21.928'	105° 03.470'	991.470	-	-	2016.04.08
44	Ц-44 ПК-20+880	4.0	49° 22.241'	105° 03.490'	986.933	3.0	2.5	2016.04.08
45	Ц-45 (Г-1) ПК-21+220	15.0	49° 22.431'	105° 03.489'	990.163	2.0	1.5	2016.04.08
46	Ц-46 (Хо-36) ПК-22+20	4.0	49° 22.856'	105° 03.580'	1036.472	-	-	2016.04.08
47	Ц-47 (Хо-37) ПК-22+280	4.0	49° 22.997'	105° 03.625'	1058.280	-	-	2016.04.08
48	Ц-48 (Хо-40) ПК-23+100	4.0	49° 23.290'	105° 04.061'	1058.223	-	-	2016.04.08
49	Ц-49 (Хо-41) ПК-23+400	4.0	49° 23.390'	105° 04.274'	1042.258	-	-	2016.04.08
50	Ц-50 (Хо-42) ПК-24+100	4.0	49° 23.759'	105° 04.335'	1010.890	-	-	2016.04.08
51	Ц-51 (Хо-43) ПК-24+540	4.0	49° 23.999'	105° 04.284'	1004.789	-	-	2016.04.09
52	Ц-52 (Хо-44) ПК-25+260	4.0	49° 24.386'	105° 04.297'	1000.739	-	-	2016.04.09
53	Ц-53 (Хо-45) ПК-25+640	4.0	49° 24.588'	105° 04.561'	977.638	-	-	2016.04.09
54	Ц-54 (Хо-46) ПК-26+80	4.0	49° 24.811'	105° 04.589'	969.446	-	-	2016.04.09
55	Ц-55 ПК-26+920	4.0	49° 25.257'	105° 04.711'	960.884	-	-	2016.04.09
56	Ц-56 ПК-27+700	4.0	49° 25.612'	105° 04.801'	964.589	-	-	2016.04.09
57	Ц-57 (Хо-47) ПК-27+980	4.0	49° 25.806'	105° 04.798'	964.318	-	-	2016.04.09
58	Ц-58 (Хо-48)	4.0	49° 26.066'	105° 04.880'	961.184	-	-	2016.04.09



	ПК-28+480							
59	Ц-59 ПК-29+20	4.0	49° 26.355'	105° 04.971'	967.589	-	-	2016.04.09
60	Ц-60 (Хо-49) ПК-29+400	4.0	49° 26.556'	105° 04.969'	972.529	-	-	2016.04.09
61	Ц-61 (Г-2) ПК-29+820	15.0	49° 26.775'	105° 04.876'	975.894	4.0	3.0	2016.04.10
62	Ц-62 ПК-30+620	4.0	49° 27.205'	105° 04.813'	996.251	-	-	2016.04.10
63	Ц-63 ПК-31+20	4.0	49° 27.427'	105° 04.870'	989.400	-	-	2016.04.10
64	Ц-64 ПК-31+520	6.0	49° 27.668'	105° 04.949'	992.014	-	-	2016.04.10
65	Ц-65 (Г-3.1) ПК-31+940	15.0	49° 27.837'	105° 05.188'	992.036	4.6	4.0	2016.04.10
66	Ц-66 (Г-3.2) ПК-31+980	15.0	49° 27.864'	105° 05.179'	991.719	4.7	4.2	2016.04.10
67	Ц-67 (Г-3.3) ПК-32+100	15.0	49° 27.887'	105° 05.314'	992.691	5.0	4.5	2016.04.10
68	Ц-68 ПК-32+740	6.0	49° 28.218'	105° 05.281'	1002.619	5.8	5.3	2016.04.10



VII. ЦОНОГИЙН БИЧИГЛЭЛ

**Объект: Дархан-Эрдэнэтийн замаас Амарбаясгалант хийд хүртлэх
33.4 км урттай, хатуу хучилттай авто замын инженер-геологийн
судалгааны ажил**

Цооног № 1

Байршил: ПК 0+40, 49°12.818', 104°59.121'

Гүн – 4.0 м

Диаметр 168-146 мм

Өндөржилт- 930.091 м

Өрөмдсөн-2016-04-04

1. Ургамлын үндэс бүхий бор хүрэн өнгөтэй шавранцар хөрс бүхий - өнгөн хөрс. (0.00-0.40)/0.40
 2. Цайвар саарал өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, хатуу консистенцтэй, шавранцар хөрс. (0.40-0.60)/0.20
 3. Бор шаргал өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, бага чийгтэй, элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс. (0.60-4.00)/3.40
- Хөрсний ус илрээгүй

Цооног № 2

Байршил: ПК 0+500, 49°59.090', 104°59.090'

Гүн – 4.0 м

Диаметр 168-146 мм

Өндөржилт- 936.002 м

Өрөмдсөн-2016-04-04

1. Ургамлын үндэс бүхий бор хүрэн өнгөтэй шавранцар хөрс бүхий - өнгөн хөрс. (0.00-0.40)/0.40
 2. Цайвар саарал өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, хатуу консистенцтэй, шавранцар хөрс. (0.40-0.70)/0.30
 3. Бор шаргал өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, бага чийгтэй, элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс. (0.70-4.00)/3.30
- Хөрсний ус илрээгүй

Цооног № 3

Байршил: ПК 1+000, 49°13.332', 104°59.047'

Гүн – 4.0 м

Диаметр 168-146 мм

Өндөржилт- 943.732 м

Өрөмдсөн-2016-04-04

1. Ургамлын үндэс бүхий бор хүрэн өнгөтэй шавранцар хөрс бүхий - өнгөн хөрс. (0.00-0.40)/0.40
 2. Бор шаргал өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, хатуу консистенцтэй, хайргархаг шавранцар хөрс. (0.40-1.40)/1.00
 3. Бор шаргал өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, бага чийгтэй, элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс. (1.40-4.00)/2.60
- Хөрсний ус илрээгүй



Цооног № 4

Байршил: ПК 1+700, 49°13.701', 104°59.037'

Гүн – 4.0 м

Диаметр 168-146 мм

Өндөржилт- 961.199 м

Өрөмдсөн-2016-04-04

1. Ургамлын үндэс бүхий бор хүрэн өнгөтэй шавранцар хөрс бүхий - өнгөн хөрс. (0.00-0.40)/0.40
2. Улаан, улаан хүрэн өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, хатуу консистенцтэй, хайргархаг шавранцар хөрс. (0.40-2.40)/2.00
3. Улаан хүрэн, улаан өнгөтэй, Палеозойн настай боржин, түүний хүчтэй өгөршил. (2.40-4.00)/1.60

Хөрсний ус илрээгүй

Цооног № 5 (Хоолой-3)

Байршил: ПК 2+180, 49°13.954', 104°58.926'

Гүн – 4.0 м

Диаметр 168-146 мм

Өндөржилт- 981.117 м

Өрөмдсөн-2016-04-04

1. Ургамлын үндэс бүхий бор хүрэн өнгөтэй шавранцар хөрс бүхий - өнгөн хөрс. (0.00-0.60)/0.40
2. Бор хүрэн, бор шаргал өнгөтэй, делюви-пролювийн гаралтай, хатуу консистенцтэй, хайргархаг шавранцар хөрс. (0.60-1.80)/1.20
3. Улаан хүрэн өнгөтэй, Палеозойн настай боржин, түүний хүчтэй өгөршил. (1.80-4.00)/2.20

Хөрсний ус илрээгүй

Цооног № 6 (Хоолой-4)

